



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан Уул аймгийн Орхон сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/102/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он	Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас:70373089, 99023682 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:99023682 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:99377479 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomaudit@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 135

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын 8 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 43.6 хувиар өссөн байна.

4525026226

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Орхон сумын 8 дугаар сургууль нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 51 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 92.5 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	154,996,733.08	124,828,754.95
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	102,825,481.70	62,929,903.57
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	102,825,481.70	62,929,903.57
31210	Төгрөг	102,825,481.70	62,929,903.57
31211	Төрийн сангийн харилцах	102,825,481.70	62,929,903.57
33	АВЛАГА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	52,171,251.38	61,898,851.38
35100	Түүхий эд материал	860,700.00	860,700.00
35130	Эм боох материал	860,700.00	860,700.00
35400	Хангамжийн материал	51,310,551.38	61,038,151.38
35410	Бичиг хэргийн материал	2,300,300.00	2,193,300.00
35420	Аж ахуйн материал	2,199,800.00	6,582,800.00
35460	Хүнсний материал	3,576,200.00	327,500.00
35470	Бусад хангамжийн материал	43,234,251.38	51,934,551.38
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,168,877,444.12	1,172,161,886.78
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,168,877,444.12	1,172,161,886.78
39200	Биет хөрөнгө	1,126,329,925.14	1,129,726,797.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,076,621,060.00	1,076,621,060.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(283,775,533.29)	(301,719,217.65)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	359,144,767.82	434,120,378.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(107,045,307.80)	(158,239,358.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	82,397,572.00	65,733,062.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,992,881.55)	(37,225,279.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,289,860.00	15,289,860.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,446,922.72)	(9,446,922.72)
39217	Ном	39,137,310.68	44,593,214.88
39300	Биет бус хөрөнгө	42,547,518.98	42,435,088.94
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(552,781.02)	(665,211.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	41,976,000.00	41,976,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,323,874,177.20	1,296,990,641.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	64,285,003.15
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	64,285,003.15
41300	Өглөг	0.00	64,285,003.15
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	3,598,103.15
41360	Бусад өглөг	0.00	60,686,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	60,686,900.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,323,874,177.20	1,232,705,638.58
51	Засгийн газрын хувь оролцоо	1,323,874,177.20	1,232,705,638.58
51100	Засгийн газрын оруулсан капитал	270,560,830.28	270,560,830.28
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	270,560,830.28	270,560,830.28
51200	Хуримтлагдсан үр дүн	68,471,012.04	(22,697,526.58)
51210	Өмнөх үеийн үр дүн	(127,179,890.54)	68,471,012.04
51220	Тайлант үеийн үр дүн	195,650,902.58	(91,168,538.62)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	984,842,334.88	984,842,334.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,323,874,177.20	1,296,990,641.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,518,545,786.04	1,843,428,954.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	188,559,970.41	32,741,654.66
120	Нийтлэг татварын бус орлого	188,559,970.41	32,741,654.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,217,148.00	492,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,066,500.00	492,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,648.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	172,120,675.41	16,548,554.66
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	15,222,147.00	15,700,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,329,985,815.63	1,810,687,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,145,082,400.00	1,606,459,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,145,082,400.00	1,606,459,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	184,903,415.63	204,227,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	184,903,415.63	204,227,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,322,894,883.46	1,934,597,493.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,322,894,883.46	1,934,597,493.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,275,003,383.46	1,869,277,481.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	833,949,779.43	1,331,956,387.04
210101	Үндсэн цалин	598,637,591.08	859,882,954.29
210102	Нэмэгдэл	202,723,931.35	435,542,679.63
210104	Урамшуулал	32,588,257.00	36,530,753.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,367,096.00	164,664,319.89
210201	Тэтгэврийн даатгал	70,357,409.85	112,165,345.92
210202	Тэтгэмжийн даатгал	8,156,885.14	13,195,869.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,480,749.05	6,624,962.70
210204	Ажилгүйдлийн даатгал	1,569,228.86	6,535,808.45
210205	Эрүүл мэндийн даатгал	15,802,823.10	26,142,333.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,212,225.63	179,433,205.79
210301	Гэрэл, цахилгаан	7,461,125.63	11,203,950.54
210302	Түлш, халаалт	157,730,900.00	159,729,615.25
210303	Цэвэр, бохир ус	9,020,200.00	8,499,640.00
2105	Нормативт зардал	30,904,124.00	25,109,152.00
210502	Хоол, хүнс	30,904,124.00	25,109,152.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,913,337.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	25,913,337.00	8,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,309,263.28	18,995,625.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	944,700.00	614,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,364,563.28	18,381,025.65
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,347,558.12	141,118,790.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,217,827.00	36,367,226.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,785,200.00	11,787,452.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,344,531.12	92,964,112.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,891,500.00	65,320,012.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,891,500.00	48,525,618.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,891,500.00	48,525,618.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	16,794,394.21
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	16,794,394.21
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	195,650,902.58	(91,168,538.62)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	195,650,902.58	(91,168,538.62)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,334,733,348.00	1,811,180,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,217,148.00	492,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,217,148.00	492,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,217,148.00	492,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,066,500.00	492,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,648.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,333,516,200.00	1,810,687,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,145,082,400.00	1,606,459,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,145,082,400.00	1,606,459,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	188,433,800.00	204,227,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	188,433,800.00	204,227,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,244,948,339.71	1,832,062,578.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,244,948,339.71	1,832,062,578.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,193,049,355.34	1,771,968,973.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	833,668,229.43	1,328,358,283.89
210101	Үндсэн цалин	598,356,041.08	856,284,851.14
210102	Нэмэгдэл	202,723,931.35	435,542,679.63
210104	Урамшуулал	32,588,257.00	36,530,753.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,367,096.00	164,664,319.89
210201	Тэтгэврийн даатгал	70,357,409.85	112,165,345.92
210202	Тэтгэмжийн даатгал	8,156,885.14	13,195,869.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,480,749.05	6,624,962.70
210204	Ажилгүйдлийн даатгал	1,569,228.86	6,535,808.45
210205	Эрүүл мэндийн даатгал	15,802,823.10	26,142,333.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,212,225.63	179,433,205.79
210301	Гэрэл, цахилгаан	7,461,125.63	11,203,950.54
210302	Түлш, халаалт	157,730,900.00	159,729,615.25
210303	Цэвэр, бохир ус	9,020,200.00	8,499,640.00
2105	Нормативт зардал	33,861,424.00	27,086,860.00
210502	Хоол, хүнс	33,861,424.00	27,086,860.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,691,190.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	10,691,190.00	8,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,309,263.28	18,995,625.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	944,700.00	614,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,364,563.28	18,381,025.65
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,939,927.00	45,430,678.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,154,727.00	33,643,226.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,785,200.00	11,787,452.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,898,984.37	60,093,604.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,898,984.37	43,299,210.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,368,600.00	43,299,210.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,530,384.37	16,794,394.21
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,530,384.37	16,794,394.21
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	89,785,008.29	(20,882,478.13)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	26,600,000.00	19,013,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,600,000.00	19,013,100.00

2200	Дотоод эх үүсвэрээр	26,600,000.00	19,013,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,600,000.00	19,013,100.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(26,600,000.00)	(19,013,100.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	63,185,008.29	(39,895,578.13)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	39,640,473.41	102,825,481.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	102,825,481.70	62,929,903.57

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1.00	2022 оны 12-р сарын 31-нээсх үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	(127,179,890.54)	1,128,223,274.62
2.00	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3.00	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	(127,179,890.54)	1,128,223,274.62
4.00	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5.00	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6.00	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7.00	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8.00	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9.00	Тайлант үеийн үр дүн	-	-	195,650,902.58	195,650,902.58
10.00	2023 оны 12-р сарын 31-нээсх үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	68,471,012.04	1,323,874,177.20
11.00	2024 оны 1-р сарын 1-нээсх үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	68,471,012.04	1,323,874,177.20
12.00	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13.00	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	68,471,012.04	1,323,874,177.20
14.00	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15.00	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16.00	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17.00	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18.00	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19.00	Тайлант үеийн үр дүн	-	-	(91,168,538.62)	(91,168,538.62)
20.00	2024 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	(22,697,526.58)	1,232,705,638.58

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,913,459,900.00	1,834,281,283.92	(79,178,616.08)	95.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,913,459,900.00	1,834,281,283.92	(79,178,616.08)	95.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,859,598,000.00	1,790,982,073.92	(68,615,926.08)	96.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,353,669,400.00	1,328,358,283.89	(25,311,116.11)	98.13
210101	Үндсэн цалин	899,945,500.00	856,284,851.14	(43,660,648.86)	95.15
210102	Нэмэгдэл	435,791,200.00	435,542,679.63	(248,520.37)	99.94
210104	Урамшуулал	17,932,700.00	36,530,753.12	18,598,053.12	203.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,208,600.00	164,664,319.89	(4,544,280.11)	97.31
210201	Тэтгэврийн даатгал	115,061,900.00	112,165,345.92	(2,896,554.08)	97.48
210202	Тэтгэмжийн даатгал	13,536,700.00	13,195,869.08	(340,830.92)	97.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,768,300.00	6,624,962.70	(143,337.30)	97.88
210204	Ажилгүйдлийн даатгал	6,768,300.00	6,535,808.45	(232,491.55)	96.56
210205	Эрүүл мэндийн даатгал	27,073,400.00	26,142,333.74	(931,066.26)	96.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	196,227,600.00	179,433,205.79	(16,794,394.21)	91.44
210301	Гэрэл, цахилгаан	11,332,500.00	11,203,950.54	(128,549.46)	98.87
210302	Түлш, халаалт	175,449,100.00	159,729,615.25	(15,719,484.75)	91.04
210303	Цэвэр, бохир ус	9,446,000.00	8,499,640.00	(946,360.00)	89.98
2105	Нормативт зардал	34,517,100.00	27,086,860.00	(7,430,240.00)	78.47
210502	Хоол, хүнс	34,517,100.00	27,086,860.00	(7,430,240.00)	78.47
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	8,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,812,700.00	18,995,625.65	(8,817,074.35)	68.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	614,600.00	614,600.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	27,198,100.00	18,381,025.65	(8,817,074.35)	67.58
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,162,600.00	64,443,778.70	(5,718,821.30)	91.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,316,300.00	52,656,326.70	(5,659,973.30)	90.29
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,846,300.00	11,787,452.00	(58,848.00)	99.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,861,900.00	43,299,210.00	(10,562,690.00)	80.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,861,900.00	43,299,210.00	(10,562,690.00)	80.39
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,861,900.00	43,299,210.00	(10,562,690.00)	80.39
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,913,459,900.00	1,794,385,705.79	(119,074,194.21)	93.78
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,709,232,300.00	1,606,459,700.00	(102,772,600.00)	93.99
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,709,232,300.00	1,606,459,700.00	(102,772,600.00)	93.99
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	204,227,600.00	187,433,205.79	(16,794,394.21)	91.78

320001	Орон нутгийн төсвөөс	204,227,600.00	187,433,205.79	(16,794,394.21)	91.78
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	492,800.00	492,800.00	0.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	492,800.00	492,800.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	102,825,481.70	102,825,481.70	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	62,929,903.57	62,929,903.57	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	56.00	56.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	36.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	19.00	19.00	-	100.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	403.00	403.00	-	100.00
630001	Төрийн өмчит ЕБС	403.00	403.00	-	100.00

/төгрөгөөр/

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Орхон сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь 2024-2025 хичээлийн жилийн эрхэм зорилгоо "Суралцах суурь чадвараа хөгжүүлсэн зөв харилцаатай эрүүл чийрэг хүүхэд төлөвшүүлнэ" гэж тодорхойлон үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тус сургууль нь хүүхдийн бие даан суралцах үйлийг дэмжин амжилттай суралцахад эцэг эх багшийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэн суралцагч өөрийгөө үнэлэн, ахицаа тооцох боломжийг бүрдүүлж, тэгш суралцах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин

Тус сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам" ;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам";
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;

1. Засгийн газрын 2024 оны 02 дүгээр сарын 28-ний өдрийн 82 дүгээр тушаалтай туслах үйлдлийн нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй бүтээл, хөгжил, тайлагналыг 15 хоногт хувиар хуваарилж хяналтын үр нөлөөтэй гэж тодорхойлсон, гүйцэтгэх үр нөлөөг хяналтын үйлдлийн хувиар хуваарилж үйлдлийн үр нөлөөтэй гэж үзсэн.

Тайлант өнд дээд шатны төсвийн захиралын эрхээр, бүтээл, хөгжил, тайлагналыг, хувиар хуваарилж, дотоод аудитараар шууд түрэлтээр явах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд хөгжил, хувиар хуваарилж, тайлагналыг 15 хоногт хувиар хуваарилж хяналтын үр нөлөөтэй гэж тодорхойлсон, гүйцэтгэх үр нөлөөг хяналтын үйлдлийн хувиар хуваарилж үйлдлийн үр нөлөөтэй гэж үзсэн.

Дархан-Уул аймгийн Орхон сумын өрөнхий боловсролын 8 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг дахь жилд гүйцэтгэх ажруул бууралт, хувиар хуваарилж, тайлагналыг 15 хоногт хувиар хуваарилж хяналтын үр нөлөөтэй гэж тодорхойлсон, гүйцэтгэх үр нөлөөг хяналтын үйлдлийн хувиар хуваарилж үйлдлийн үр нөлөөтэй гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлого, толилуулалт, тус байгууллагын үйлдлийн хувиар хуваарилж, тайлагналыг 15 хоногт хувиар хуваарилж хяналтын үр нөлөөтэй гэж тодорхойлсон, гүйцэтгэх үр нөлөөг хяналтын үйлдлийн хувиар хуваарилж үйлдлийн үр нөлөөтэй гэж үзсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулалт, туслах үйлдлийн үр нөлөө

Дархан-Уул аймгийн Орхон сумын өрөнхий боловсролын 8 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дүгээр зүйлийн 3.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөтөлмөрийн бодлого, толилуулалт, туслах үйлдлийн үр нөлөөтэй гэж тодорхойлсон, гүйцэтгэх үр нөлөөг хяналтын үйлдлийн хувиар хуваарилж үйлдлийн үр нөлөөтэй гэж үзсэн.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт төсвийн дүн өмнөх оноос 20,883.5 мянган төгрөгөөр буюу 2.03 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	102,825.5	62,929.9	(39,895.6)
Авлага	-	-	-
Бариа материал	52,171.3	61,898.3	9,727.0
Үндсэн хөрөнгө	1,163,877.4	1,172,131.3	8,253.9
Нийт хөрөнгө	1,323,874.2	1,296,960.3	(26,913.9)
Богино хугацаат өр төлбөр	-	64,235.0	64,235.0
Эздийн өмчийн дүн	1,323,874.2	1,232,725.3	(91,148.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,323,874.2	1,296,960.3	(26,913.9)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 62,929.9 мянган төгрөг болж өмнөх оноос 39,895.6 мянган төгрөгөөр буурсан нь тухайн байгууллагын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хэсгээр баталсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 61,898.9 мянган төгрөг болж 9,727.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 108,810.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, Орхон сумын Засаг даргын тамгын газар, сумын нотариатын газраас 8,700.3 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар, Санко маркетинг монголиа ХХК-с цахим ангийн тоног төхөөрөмж суурилуулалт угсралтын ажилд 7,000.0 мянган төгрөгийн бараа материалыг тус тус орлогоор хүлээн авч бүртгэн, 114,783.2 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,172,161.9 мянган төгрөг болж өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалт, нөхөн хангалтын зардлаас 79,900.0 мянган төгрөгийн цахим ангийн тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авч, цахим сүлжээ суурилуулах ажлыг Санко маркетинг монголиа ХХК-р хийж гүйцэтгүүлэн бүрэн ашиглалтад оруулсан, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас хандиваар ирсэн 1,125.0 мянган төгрөгийн цэвэр ус шүүгч, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 2,486.3 мянган төгрөгийн смарт телевизор, 7,356.3 мянган төгрөгийн нөтбүүкүүд, 5,455.9 мянган төгрөгийн ном сурах бичгийг үнэ төлбөргүй хүлээн авч тушаал шийдвэрүүдийг үндэслэн холбогдох дансуудад бүртгэсэн, аймгийн Засаг даргын 2024 оны 07-р сарын 03 ны өдрийн 01-А/313 тоот захирамжаар 32,481.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасаж тайлан тодруулгад тусгасан байна. Тайлант хугацаанд 92,964.1 мянган төгрөгийн элэгдэл тооцож, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,232,705.6 мянган төгрөг болж 91,168.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургууль нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,126,388.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 204,227.6 мянган төгрөг, нийт зарлагыг 1,330,616.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг улсын төсвийн санхүүжилтийг 26,817.3 мянган төгрөгөөр бууруулж 1,099,571.4 мянга, орон нутгийн төсвийг хэвээр үлдээж 203,140.3 мянган төгрөг, нийт 1,302,711.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн хуваарьт 8 удаа өөрчлөлт орж, улсын төсвийг 609,660.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгол хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,606,459.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 204,227.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 102,772.6 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, нийт 1,913,459.9 мянган төгрөг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,606,459.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 204,227.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 492.8 мянган төгрөг нийт 1,811,180.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарлагын гүйцэтгэл 1,834,281.3 мянган төгрөг буюу 95.9 хувьтай зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 16,794.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлснээр мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 62,929.9 мянган төгрөг болж буурсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Код	Нэр				
1	80111	Тогтмол зардал	204,227.6	187,433.2	(16,794.4)	91.8
2	80226	Байр ашиглалт үйлчилгээ	2,902.9	2,902.9	0.0	100.0
3	80233	Хүүхэд хамгаалал	3,088.2	3,088.2	0.0	100.0

/мянган төгрөгөөр/

4	80312	Сургалт семинарын зардал	2,185.6	1,450.0	(735.6)	65.3
5	81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	2,907.7	1,782.0	(1,125.7)	61.3
6	81801	Үдийн цай хөтөлбөр	53,891.9	43,299.2	(10,592.7)	80.4
7	81806	Дотуур байрны хүүхдийн хоол	178,034.5	170,420.8	(7,613.6)	95.7
8	81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	19,013.1	19,013.1	0.0	100.0
9	81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	8,976.0	6,507.0	(2,469.0)	72.5
10	81834	Боловсролын стандарт	1,416,860.5	1,379,453.5	(37,407.0)	97.4
11	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа хангах	16,581.7	16,266.4	(315.3)	98.1
12	81875	Сурах бичиг түрээс	614.6	614.6	0.0	100.0
13	81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	4,205.6	2,040.4	(2,165.2)	48.5
Нийт дүн			1,913,459.9	1,834,281.3	(79,178.6)	95.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:

2024 оны худалдан авах ажиллагааг урсгал төсвийн хүрээнд хуулийн дагуу хугацаанд нь tender.gov.mn, shilendans.gov.mn сайтуудаар байршуулан нийтэлж, тайланг цахим болон цаасаар хүргүүлж ажилласан байна. tender.gov.mn сайтад хүүхдийн хоол, хүнсний нээлттэй тендер шалгаруулалтыг тайлагнаж ажиллажээ. Тус тендерийг тайлант онд 3 удаа зарласан боловч оролцогч ирээгүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.4.3-т заасны дагуу гэрээт байгууллагуудтай хамтран ажиллах, шууд худалдан авах гэрээг хийж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Пийк Ом Аудит ХХК-ын аудитор А.Батболд гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан хянан удирдаж, чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Орхон сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 1,326,415.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 26,528.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд алдаа зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 40,551.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 1 төлбөрийн акт, 5 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	222.8	1	222.8	100
Зөвлөмж	5	40,328.8	5	40,328.8	100
Нийт дүн	6	40,551.6	6	40,551.6	100

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 69,000.3 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс 49,123.2 мянган төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 347.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 19,529.9 мянган төгрөгийн зөрчилд дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитын явцад дараах алдаанууд илэрсэн. Үүнд:

- 2024 онд орлого авсан үндсэн хөрөнгийн ашиглах жил оруулаагүй, хөрөнгийн орлого авсан он сарыг буруу оруулсанаас 1,237.3 мянган төгрөгөөр элэгдлийн зардлыг дутуу тооцсон,
- Боловсролын Ерөнхий Газрын хөрөнгө оруулалтаар ирсэн 124 нэр төрлийн 5,455.9 мянган төгрөгийн ном сурах бичгийг орлого аваагүй,
- Аймгийн Засаг даргын захирамжаар актлах 1,365.4 мянган төгрөгийн хөрөнгийг дутуу акталсан,
- Боловсролын Ерөнхий Газрын хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй ирсэн 8,700.3 мянган төгрөгийн бараа материалыг ангилал буруу илэрхийлсэн,
- Мөнгөн гүйлгээний тайланд 16,794.4 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг тусгаагүй, мөнгөн гүйлгээний тайлан буруу илэрхийлэгдсэн,
- Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдлийн хуримтлагдсан үр дүн 15,569.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн тайлан,

Нийт 49,123.2 мянган төгрөгийн алдаатай тайлагнасныг УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Сангийн сайдын 2005 оны А/03 дугаар тушаал тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулав.

5.1 Төлбөрийн акт

Бичиг хэргийн ажилтан Б.Отгонжаргад эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүй 347.2 мянган төгрөгийн хавсран ажилласны нэмэгдэл хөлс олгосон нь "Төсвийн тухай хуулийн 5.1.5-д " хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй тул төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 3,598.1 мянган төгрөгийн ХХОАТ-н өр төлбөр үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх.

2. Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал, ур чадварын нэмэгдлийг тушаал, шийдвэргүйгээр 15,931.8 мянган төгрөгийг олгосон. нь БШУ-ны сайдын 2024 оны А/115 тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам"-ын дагуу зохион байгуулсан "Багшийн ажлыг үнэлсэн гүйцэтгэлийн үнэлгээ", 2022 оны А/430 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх "... багшийн ажлын үнэлгээний үр дүнд үндэслэн багшид Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолд заасан мөнгөн урамшууллыг доор дурдсан хувь хэмжээгээр албан тушаалын сарын үндсэн цалингаас тооцож

олгоно, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны хамтарсан "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" А/35, А10/9 дугаар тушаалаар батлагдсан Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх.

3. Тус сургууль нь хууль тогтоомжийн хүрээнд ахмадын сан байгуулаагүй нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган, цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 1.3 дахь "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын санг байгуулах, мөн алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд элэгдлийн зардлыг дутуу тооцсон.	1	1,237.3			1	1,237.3	1	1,237.3				
Ном сурах бичгийг орлого аваагүй	1	5,455.9	1	5,455.9			1	5,455.9				
Захирамжаар актлах хөрөнгийг дутуу акталсан.	1	1,365.4	1	1,365.4			1	1,365.4				
Мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг тусгаагүй.	1	16,794.4	1	16,794.4			1	16,794.4				
Бараа материалыг ангилал буруу илэрхийлсэн.	1	8,700.3			1	8,700.3	1	8,700.3				
Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэлийн хуримтлагдсан үр дүн зөрүүтэй илэрхийлсэн тайлан ирүүлсэн	1	15,569.9			1	15,569.9	1	15,569.9				
	6	49,123.2	3	23,615.7	3	25507,5	6	49,123.2	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хавсран ажилласны нэмэгдэл цалин олгосон.	1	347.2	1	347.2								
Өр төлбөрийн тооцоо үүссэн.	1	3,598.1					1	3,598.1				
Тушаал, шийдвэргүйгээр нэмэгдэл хөлсолгосон.	1	15,931.8					1	15,931.8				
Нийт дүн	3	19,877.1	1	347.2			2	19,529.9				